



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2026 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ТАЙЛАН

2026 оны 02 дугаар сарын 06

Улаанбаатар хот

НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1.“Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.” зорилтын хүрээнд:


1.1.1.“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор 2026 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний хуваарийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлсэн.

  2026 UB TOURISM EVENT	
2026.01.31-02.01	"ULAANBAATAR" WINTER FESTIVAL
2026.02.28-03.01	"ULAANBAATAR" WINTER WALKING FESTIVAL
2026.03.07-08	EAGLE FESTIVAL
2026.03.22	NAURYZ FESTIVAL
2026.05.08-10	"POWER EXPO" FESTIVAL
2026.05.31	THE BUDDHA PURNIMA
2026.06.06-07	"STEPPE WIND" INTERNATIONAL MOTO FESTIVAL
2026.06.12-14	"TENDER" SHAMAN FESTIVAL
2026.06.20	"REGGAE" MUSIC FESTIVAL
2026.06.27-28	CITIZEN'S DAY OF ULAANBAATAR KHUREE TSAM-DANSHIG NAADAM
2026.07.02-04	"PLAYTIME" INTERNATIONAL MUSIC FESTIVAL
2026.07.09	"DEELTEI MONGOL" FESTIVAL
2026.08.06-09	"UB FOOD" FESTIVAL
2026.08.28-30	"ULAANBAATAR" WALKING INTERNATIONAL FESTIVAL
2026.09.05-06	THE "THOUSAND HORSEMEN" FESTIVAL
2026.09.05-06	"KHIIMORI" HORSEBACK ARCHERY FESTIVAL
2026.09.05-10	"CROSSING BRIDGES 23" INTERNATIONAL PHOTOGRAPHY FESTIVAL

  2026 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУВААРИЙН	
2026.01.31-02.01	"УЛААНБААТАР" ӨВЛИЙН НААДАМ
2026.02.28-03.01	"УЛААНБААТАР" ӨВЛИЙН ЯВГАН АЛХАЛТЫН ӨДРҮҮД
2026.03.07-08	БҮРГЭДИЙН БАЯР
2026.03.22	НАРНЫ БАЯР /НАУРЫЗЫН БАЯР/
2026.05.08-10	"ПОВЕР ЭКСПО" АВТО УРАЛДААН
2026.05.31	БУРХАН БАГШИЙН ИХ ДҮЙЧИН ӨДӨР
2026.06.06-07	"ТАЛЫН САЛХИ" ОЛОН УЛСЫН МOTO НААДАМ
2026.06.12-14	"ТЭНГЭР" БӨӨГИЙН НААДАМ
2026.06.20	"РЭГГИ" ХӨГЖИЙН НААДАМ
2026.06.27-28	НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭДИЙН ӨДӨР "ХҮРЭЭ ЦАМ-ДАНШИГ НААДАМ"
2026.07.02-04	"ПЛЭИТАЙМ" ОЛОН УЛСЫН ХӨГЖИЙН НААДАМ
2026.07.09	"ДЭЭЛТЭЙ МОНГОЛ" НААДАМ
2026.08.06-09	"УБ ФУУД" ОЛОН УЛСЫН ХООЛНЫ ӨДРҮҮД
2026.08.28-30	"УЛААНБААТАР" ОЛОН УЛСЫН ЯВГАН АЛХАЛТЫН ӨДРҮҮД
2026.09.05-06	"МЯНГАН МОРЬТОН" НААДАМ
2026.09.05-06	"ХИЙМОРЬ" МОРЬТ ХАРВААНЫ ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН

1.1.2.“Монгол Улсад 2026 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн цаглавар”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд танилцуулж, нэгдсэн цаглаварт нийт 140 арга хэмжээ буюу спортын 14, соёл, аялал жуулчлалын 99, /MICE tourism/ буюу олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн 27 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөгдөж, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас зохион байгуулах аялал жуулчлалын 16 эвент арга хэмжээ тусгагдан 2026 оны 01 дүгээр сард “Талын жавхаа”, “Улаанбаатар өвлийн наадам” 2 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгууллаа.

[illegible]





“Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээ

1.1.4. Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үндэсний тоглоом наадгай болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 14 дэх удаагийн “Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээг “Скай резорт” цанын баазад 2026 оны 01 дүгээр сарын 31, 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав.

“Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээний хүрээнд Мөсөн сурын олон улсын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдингийн (уулын шүхэр) Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Снөүбоардын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Уулын цанын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Кёрлингийн Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, “Grand tour winter cup 2026” аялал жуулчлалын салбарын оюутнууд дундах буухиа тэмцээн зэрэг 7 төрлийн уралдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, Бүгд найрамдах Халимаг улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгур, БНКазахстан Улс, АНУ зэрэг улсаас 46, Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотоос 1500 гаруй хүн оролцлоо.

Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн хана авиралтын тэмцээн зохион байгуулж, мөн параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр танилцуулга, банхар нохдын үзүүлбэр танилцуулга, цана чарганы үйлчилгээ, хоол ундны үйлчилгээ, цаа буга, морь, тэмээ унах үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхлоо.





1.2. “Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулна.” зорилтын хүрээнд:

1.2.1. “Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах” зорилтын хүрээнд Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалын хөгжүүлэх зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Талын Жавхаа”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр зэрэг 5 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, 2026 оны 01 дүгээр сард 2 арга хэмжээг зохион байгууллаа.

ULAANBAATAR
WINTER FESTIVAL
PROGRAM

DATE: JANUARY 31, 2026

Time	Program
09:00-16:00	Sports competitions begins (Ice Archery, Ice Ankle-bone Shooting, Curling, Paragliding, Snowboarding, Alpine Skiing, Ice Wall Climbing)
12:00-12:10	Opening ceremony
12:10-12:15	National Anthem of Mongolia (Paragliding with the National Flag)
12:15-12:30	- Torch Lighting Ceremony of the Ulaanbaatar Winter Festival - Ceremony of Presenting the National Flag of Mongolia and the Flag of Ulaanbaatar City to the city officials - Colorful Fireworks
12:30-12:45	- Performance by the Rhythmic Drum Band - Grand Respect Dance - Singer: T.Tsogsgomaa - Singer: B.Bayanjargal
13:50-14:30	DJ Performances
14:30-15:00	- Singer: B.Odmandakh "Ertnei Tsuurai" band - Traditional Folk Performance
15:00-16:00	- Singer: A.Otgonbold and A. Naranbaatar - Artists of the Ulaanbaatar Theater "Honor Dance" choreography by D. Enkhgerel - Artists of the Ulaanbaatar Theater - Singer: M.Otgonjargal - Ethnic Artist: D. Shijirmaa
16:30-16:50	Ethnic Artist: D. Shijirmaa
18:50-17:00	Closing Ceremony

Note: Tug-of-War, Family Bowling, Ice Wall, and Ice Archery for amateurs will be announced during the event.



2026.01.31-02.01
AT SKY RESORT

ULAANBAATAR
WINTER FESTIVAL
PROGRAM

DATE: FEBRUARY 01, 2026

Time	Program
09:00	Sports competitions begins (Ice Archery, Ice Ankle-bone Shooting)
11:30-12:00	DJ Performance
12:00-12:30	Opening Ceremony of the "Grand Tour Winter Cup 2026" - Winter Sports Competition for Tourism Students
12:30-12:40	"Ertnei Tsuurai" band - Traditional Folk Performance - Singer: B.Bayanjargal
12:40-15:10	Activities by Mongol Bankhar Enthusiasts
13:40-13:50	- Singer: M.Otgonjargal - Singer: T.Tsogsgomaa
13:50-15:00	"Grand Tour Winter Cup 2026" - Winter Sports Competition for Tourism Students
15:00-15:20	- Ice Wall Climbing Competition - Curling Competition "Honor Dance" choreography by D. Enkhgerel - Artists of the Ulaanbaatar Theater - Singer: A.Otgonbold and A. Naranbaatar - Artists of the Ulaanbaatar Theater
15:20-15:40	- Singer: B.Odmandakh - Ethnic Artist: D. Shijirmaa
15:40-17:00	Award Ceremony for Sports Competitions

2026.01.31-02.01
AT SKY RESORT



“UB WINTER SALE”




1.2.2. Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, өвлийн улиралд бизнесийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран “UB WINTER SALE” аяныг 3 дахь жилдээ зохион байгууллаа.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа соёл урлаг, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний 52 аж ахуйн нэгж, байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 5-70 хувь хүртэл хөнгөлөлт, урамшуулалтай үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүллээ.



1.3. “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэд технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчилах” чиглэлээр:

1.3.1. “Улаанбаатарын өвлийн наадам”, “Талын жавхаа” зэрэг 2 арга хэмжээний танилцуулга 2 видео, контент хийж байгууллагын www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net цахим хуудас болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд байршуулж 992,728 хүнд хүргэсэн байна.



ХОЁР.ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;

2.1.1. “Онлайн бизнес төв” нэгдсэн мэдээллийн системийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэл” цэсэд 2026 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдээс зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр нийт 47 хүсэлт ирснээс зөвшөөрсөн 25, хариуцсан дүүрэгт шилжүүлсэн 6, буцаагдсан 16 төлөвтэй байна.

2.2. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;

2.2.1. “Цайны зам”-ын олон улсын холбооны гишүүн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны санхүүжилтээр тохижуулах Налайх дүүргийн нутаг дэвсгэр байрлах “Жуулчин төгөл” төслийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төслийн баримт бичгүүдийг холбогдох байгууллагуудад хянуулахаар хүргүүлэв.

2.3. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;




2.3.1. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, чиг үүргийн байгууллагуудтай хамтран “Аялал жуулчлалын салбар дахь татвар, даатгал, харилцааны менежмент, дипломат үйлчилгээний сургалт”-ыг 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр, жуулчдыг болзошгүй гамшиг, ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль эрх зүй, стандарт, аюулгүй байдлын чиглэлээр “Гамшгаас хамгаалах сургалт”-ыг 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр тус тус зохион байгуулагдах сургалтуудын бэлтгэлийг хангаж ажиллаа.



2.4. “Жуулчны мэдээллийн төв”-үүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх;

2.4.1. Нийслэлийн Засаг даргын 2026 оны “Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/107 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал, Сөүлийн гудамж дахь “Урухан” брэндийн гэр мэдээллийн төв болон ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв зэрэг 4 байршилд ажиллуулж 2025 оны 01 дүгээр

сард гадаад, дотоодын 413 хүнд үйлчилгээ үзүүлж, Улаанбаатар хотын сурталчилгааны нийт 230 ширхэг материалыг хүргэсэн.



ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

3.1.Захиргааны үйл ажиллагаа, төлөвлөлт, тайлагналтын чиглэлээр:

3.1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2026 оны "Хариуцлагын гэрээ"-г 6 бүлэг 48 заалтаар, Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын хүрээнд 12 зорилтын 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулав.

3.1.2.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан "Төрийн зарим чиг үүргийг 2026 онд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ"-ний хүрээнд аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх 16 арга хэмжээний санал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

3.1.3. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хариутай 16 албан бичиг, хариугүй 20 албан бичиг нийт 36 албан бичгийг бүртгэж, 54 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу боловсруулан бусад байгууллагуудад илгээсэн. Ирүүлсэн 36 албан бичгийг бүрэн шийдвэрлэсэн. Албан бичгийн шийдвэрлэлт 100 хувийн үзүүлэлттэй байна.

3.1.4. Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2026 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Нийт өргөдөл, гомдлоос албан хаагчийн ёс зүйн

зөрчилтэй холбоотой гомдол болон саналын шинжтэй өргөдөл ирээгүй бөгөөд шийдвэрлэлтийн явцад хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 13 хоног 05 цаг 02 минут байна.

3.1.5. Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын хүрээнд 5 бүлгийн 87 үзүүлэлтийн мэдээллийг улирал бүр <http://www.frontoffice-dev.shilen.gov.mn/> цахим хуудсанд тогтсон хугацаанд байршуулж, 2025 оны IV улирлын дүнгээр 97 хувиар баталгаажсан.

3.1.6. Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn, www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд давхардсан тоогоор 209 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 1,229,557 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан.

Тухайлбал:

www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 28 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 1350,

www.visit-ulaanbaatar.com цахим хуудсанд 5 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 99,780

<https://www.facebook.com/UlaanbaatarTourism> цахим хуудсанд 163 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 37,613 хандалтын тоо 913,600

<https://www.instagram.com/visit.ulaanbaatar/> цахим хуудсанд 10 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 412, хандалтын тоо 210,000

<https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA> цахим хуудсанд 3 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 513, хандалтын тоо 4827 байна.

3.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

3.2.1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2026 оны сургалтын төлөвлөгөөний дагуу төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1, "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах" сэдэвт сургалтад 10, "Цахим орчны боломж ашиглан ажлын бүтээмж нэмэгдүүлэх нь" сэдэвт сургалтад 1, Монгол бичгийн сургалтад 1 буюу нийт 4 удаагийн сургалтад 13 албан хаагчийг хамруулсан.

3.2.2. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулан 15 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.

3.2.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 10 албан хаагч хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд тайлагнасан.


ТАНИЛЦСАН:
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН



О.НЯМБАТ